



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 1/99

Батноров сум

Г Т

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн журам)-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Бэрх тосгоны орон сууц дээвэр засварын” ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заагдсан хугацаанд тус ажлыг бүрэн гүйцэд хийлгэн хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Ган-эрдэнэ (Засаг даргын орлогч)
Гишүүд:	Г.Цолмонтuya (Соёл сангийн нягтлан бодогч)
	Ч.Энхжавхлан (Бэрх хотын захирагч)
	Э.Мягмарсүрэн (Захирагчийн ажлын албаны дарга)
	Б.Болормаа (Бэрх хотын ХТАТҮГ дарга)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, явцын чанар, ажлын тоо хэмжээ, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагч байгууллагыг бүрэн төлөөлж хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмолжуулан удирдлагыг мэдээллээр хангаж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, явцын дүгнэлт, гүйцэтгэлд акт үйлдэн тус ажлыг бүрэн хүлээж авах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР